



**ЗАМ, ТЭЭВРИЙН
ХӨГЖЛИЙН ЯАМ**

**ДАЛАЙ АШИГЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ
ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**Улаанбаатар хот
2018 он**

ГАРЧИГ

УДИРТГАЛ	3
НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	3
1.1. Үнэлгээ хийх шалтгаан.....	3
1.2. Үнэлгээ хийх хүрээ.....	4
1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлт.....	6
1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр.....	7
1.5. Шалгуур үзүүлэлт тодорхойлох.....	11
1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.....	12
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	14
2.1. Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах.....	14
2.2. Холбогдох субъектээс судалгаа авах.....	16
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ	16
3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:.....	17
3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:.....	19
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	22
4.1. Үнэлгээний дүгнэлт.....	22
4.2. Зөвлөмж.....	25
ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ	27

УДИРТГАЛ

1999 онд батлагдсан Далай ашиглах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийв. Үнэлгээ хийх ажлын зорилт нь Далай ашиглах тухай хуулийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид тухайн хуулийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлоход оршино. Үнэлгээг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 157 дугаар тушаалаар байгуулагдсан Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг хийж гүйцэтгэсэн болно. Тус үнэлгээ нь төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн гурван үе шатаас бүрдэнэ.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Төлөвлөх шатны зорилго нь үнэлгээ хийх хүрээг тогтоож түүнд тохирсон шалгуур үзүүлэлтийг тодорхойлоход чиглэгдэнэ. Энэ үе шатанд дараах алхмуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:

- Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
- Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
- Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
- Харьцуулах хэлбэрийг сонгох;
- Шалгуур үзүүлэлтийг томъёолох;
- Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

1.1. Үнэлгээ хийх шалтгаан

Хууль тогтоомж нь тухайн харилцааг зохицуулж байгаа эсэх болон нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх зорилгоор үнэлгээний ажлын эхэнд үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлно. Ингэхдээ “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын 3.2-т заасан нөхцөл байдлыг үндэслэв.

Далай ашиглах тухай хууль нь 1999 онд батлагдсан бөгөөд түүнээс хойш нэг удаа /2007 онд/ нэмэлт, өөрчлөлт орсон боловч Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцид заасан зайлшгүй биелүүлэх хэм хэмжээнүүдийг үндэсний хууль тогтоомждоо бүрэн тусгаагүй буюу зайлшгүй зохицуулах ёстой харилцааг хамарч зохицуулаагүй байна.

Монгол Улс нь 1921 оны “Далайд гарцгүй улсуудын далбаагаа мандуулах эрхийг хүлээн зөвшөөрөх тухай” Барселоны тунхаглал¹, 1948 оны “Олон улсын

¹ БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1976 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 170 дугаар зарлигаар нэгдэн орсон.

далайн байгууллагын тухай конвенц”², 1982 оны “Далайн эрх зүйн тухай НҮБ-ын конвенц”³ зэрэг олон улсын далайн салбарын 29 конвенц, протоколд нэгдэн орсон.

Олон улсын далайн байгууллагаас гишүүн улс, орнуудад нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцийн дагуу хүлээсэн эрх, үүргээ хэрхэн хэрэгжүүлж байгаад аудитын шалгалт явуулдаг бөгөөд Монгол Улс далбааны эзэн улсын⁴ эрх үүргээ хэрхэн хэрэгжүүлж буй байдалд 2016 оны 11 дүгээр сард аудитын шалгалт хийсэн.

Уг аудитын дүгнэлтээр далайн тээврийн салбар өндөр хөгжсөн улсуудтай харьцуулахад энэ салбарын хөгжил дөнгөж эхний үе шатандаа яваа Монгол Улсын хувьд хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, ингэхдээ олон улсын гэрээ, конвенцид заасан зайлшгүй биелүүлэх хэм хэмжээнүүдийг үндэсний хууль, тогтоомждоо тусгах буюу Далай ашиглах тухай хуулийг шинэчлэх шаардлага байгааг онцлон тэмдэглэсэн.

Эндээс үзэхэд “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын 3.2.2-т заасан “зайлшгүй зохицуулах ёстой харилцааг хамарч зохицуулаагүй” гэсэн шалтгаан, үндэслэлийг хангасан гэж үзэж байна. Иймд тус үнэлгээг үргэлжлүүлэн хийв.

1.2. Үнэлгээ хийх хүрээ

Үнэлгээний хүрээг тогтооход хуулийн зорилгыг хэрэгжүүлэхэд чухал нөлөөлөл үзүүлэх зарим зохицуулалтыг тусгайлан сонгож үнэлгээ хийх нь илүү үр дүнтэй байдгийг харгалзан агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх, мөн үнэлэх боломжтой зарим зохицуулалтыг уг аргачлалын дагуу тусгайлан сонгож хийсэн болно.

Олон улсын далайн байгууллагаас Монгол Улс далбааны эзэн улсын⁵ эрх үүргээ хэрхэн хэрэгжүүлж буй байдалд хийсэн аудитын шалгалтаар дараах зөвлөмжүүдийг өгсөн. Үүнд:

- Монгол Улс нэгдэн орсон Олон улсын далайн байгууллагын баримт бичгийг үндэсний хууль тогтоомжид нийцүүлэхэд төрийн зүгээс хангалттай нөхцөлийг бүрдүүлэх;

- Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын далайн байгууллагын заавал дагаж мөрдөх баримт бичигт орж буй нэмэлт, өөрчлөлтөд байнгын хяналт-

² Монгол Улсын Их Хурлын 1996 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн хуулиар “Олон улсын далайн байгууллагын тухай конвенц”-ийг хүлээн зөвшөөрч, түүнд нэгдэн орсон.

³ Монгол Улсын Их Хурлын 1996 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн хуулиар “Далайн эрх зүйн тухай НҮБ-ын Конвенц”-ийг Засгийн газраас өргөн мэдүүлсний дагуу соёрхон баталсан.

⁴ Олон улсын хэм хэмжээний дагуу далайн тээврийн салбар дахь аливаа улсын эрх үүргийг эргийн улсын (coastal state), боомтын улсын (port state), далбааны улсын (flag state) эрх үүрэгт ангилдаг. Далайд гарцгүй Монгол Улс хөлөг онгоц бүртгэх үйл ажиллагааны хүрээнд далбааны улсын (flag state) эрх үүргийг хэрэгжүүлэн ажилладаг.

⁵ Олон улсын хэм хэмжээний дагуу далайн тээврийн салбар дахь аливаа улсын эрх үүргийг эргийн улсын (coastal state), боомтын улсын (port state), далбааны улсын (flag state) эрх үүрэгт ангилдаг. Далайд гарцгүй Монгол Улс хөлөг онгоц бүртгэх үйл ажиллагааны хүрээнд далбааны эзэн улсын (flag state) эрх үүргийг хэрэгжүүлэн ажилладаг.

шинжилгээ, үнэлгээ хийж, үндэсний хууль тогтоомжид тусгах асуудлыг боловсруулж батлуулах чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагыг төрийн зүгээс байгуулах;

- Энэхүү нэмэлт, өөрчлөлтүүдийг хүчин төгөлдөр болох огнооны дэс дараагаар нь эрэмбэлж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үндэсний хууль тогтоомжид тусган боловсруулж батлуулах арга хэмжээ авах;

- Олон улсын далайн байгууллагын заавал дагаж мөрдөх бүх хэм хэмжээнүүдийг хуулийг дагалдан гарах, хэрэгжүүлэх дүрэм, журамд тусгах;

- Улс нь Дипломтой далайчдыг бэлтгэх болон ээлжийн ажиллагааны тухай 1978 оны конвенци, түүнд Олон улсын далайн байгууллагын Ерөнхий Ассамблейн А.1047(27) дугаар шийдвэрээр оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах;

- Хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагад эрх шилжүүлэхтэй холбоотой журмыг Олон улсын далайн байгууллагаас гаргасан дүрэм, журмын дагуу боловсруулах, Хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагын эрх, үүргийг тодорхой тусгах;

- “Хөлөг онгоцыг алсын зайнаас удирдах систем”-ийн шаардлагыг хэрэгжүүлэх үндэсний хууль тогтоомж, дүрэм, журмыг баталж хэрэгжүүлэх;

- Шинээр батлагдах Далайн ашиглах тухай хууль болон бусад холбогдох хуульд хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын талаарх зохицуулалтыг оруулах. Хариуцлагын талаарх зохицуулалтын хэрэгжилтийг Засгийн газраас байгуулагдсан эрх бүхий байгууллага хянах зэрэг болно.

Аудитын энэхүү дүгнэлтийг харгалзан Далай ашиглах тухай хуулийн 2, 3, 5 дугаар бүлгийн холбогдох зүйлүүдийн зохицуулалт нь Олон улсын далайн байгууллагын зайлшгүй мөрдөх ёстой “Далайд хүний аюулгүй байдлыг хангах тухай 1974 оны олон улсын конвенц, “Хөлөг онгоцноос үүдэлтэй бохирдлоос сэргийлэх тухай” олон улсын конвенц, “Дипломтой далайчдыг бэлтгэх болон ээлжийн ажиллагааны тухай” олон улсын гэрээ, конвенцийг хэрэгжүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг хамарч зохицуулаагүй гэж үзэн үнэлгээ хийх хүрээг тодорхойлсон болно. Үүнд:

Хоёрдугаар бүлэг. Далай ашиглах үйл ажиллагаа

7 дугаар зүйл. Техникийн хяналтыг хэрэгжүүлэх

8¹ дүгээр зүйл. Далайн захиргаа

Гуравдугаар бүлэг. Далай ашиглах үйл ажиллагаа

11 дүгээр зүйл. Хөлөг онгоцны бүртгэл

Тавдугаар бүлэг. Бусад

22 дугаар зүйл. Далай ашиглах тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлт

Энэхүү үнэлгээг хийхдээ Далай ашиглах тухай хуулийн холбогдох хэсэгт үнэлгээ хийх шалтгаантай уялдуулан аргачлалд заасны дагуу 6 шалгуур үзүүлэлтээс 2 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрсэн түвшин;
2. Практикт нийцэж байгаа байдал.

Шалгуур үзүүлэлт тус бүрийн ялгаа, онцлогийг дурдвал:

д/д	Шалгуур үзүүлэлт	Ойлголт, онцлог	Жишээ тайлбар
1	Зорилгод хүрсэн түвшин	Тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойшхи хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг тогтооно	Далай ашиглах тухай хуулийн зорилтыг “Монгол Улсын Төрийн далбаа мандуулсан хөлөг онгоцоор далайн баялаг олборлох, загас агнах, тээвэр хийх зэрэг далай ашиглах үйл ажиллагаа явуулах, далай дахь аюулгүй байдлыг хангах, далайн орчныг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж тодорхойлсон. Энэ тохиолдолд Далай ашиглах тухай хууль бүхэлдээ болон сонгосон зохицуулалт энэ зорилгодоо хүрч чадсан эсэхийг үнэлэх ёстой. Хуульд үндсэн зорилгоос гадна бүлэг, хэсэг, зүйл бүрт тодорхойлсон дагалдах зорилго байж болох бөгөөд үүнийг давхар шалгаж болно.
2	Практикт нийцэж байгаа байдал	Тухайн хууль тогтоомжийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлно.	Хуулийн ойлгомжтой байдал, хэрэгжүүлэх боломж бололцоо практикт байгаа эсэхийг тодорхойлно.

“Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал:

Далай ашиглах тухай хуулийн 1 дүгээр зүйлд хуулийн зорилтыг “Монгол Улсын Төрийн далбаа мандуулсан хөлөг онгоцоор далайн баялаг олборлох, загас агнах, тээвэр хийх зэрэг далай ашиглах үйл ажиллагаа явуулах, далай дахь аюулгүй байдлыг хангах, далайн орчныг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж тодорхойлжээ. Үүнээс үзэхэд Далай ашиглах тухай хуулийн үндсэн зорилтын нэг бол далай ашиглах үйл ажиллагаа явуулахтай холбогдсон харилцааг зохицуулах болох нь харагдаж байна. Иймд энэхүү

үнэлгээний шалгуур үзүүлэлтийг сонгохдоо дээр дурдсан зорилтыг хангахтай холбогдуулан тусгасан зүйл, заалтыг сонгож “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлгээ хийх нь зүйтэй гэж үзлээ.

1.3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал:

Далай ашиглах үйл ажиллагаа болон хөлөг онгоцны бүртгэл нь Монгол Улсын хилийн гадна явагдаж байгаа учраас хэрэгжилтийн асуудлыг практикт хэрхэн хэрэгжүүлж байгаа асуудалд үнэлгээ хийх шаардлагатай гэж үзэв.

1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ үнэлэх болсон шалтгаан, үнэлгээний хүрээ, шалгуур үзүүлэлт зэргийг харгалзан дор дурдсан харьцуулах хэлбэрүүдээс сонгов.

- Байх ёстой болон одоо байгаа;
- Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойш;
- Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш;
- Тохиолдол судлах.

Харьцуулах хэлбэр тус бүрийн онцлогийг дурдвал:

№	Харьцуулах хэлбэр	Ойлголт, онцлог
1	Байх ёстой болон одоо байгаа	Далай ашиглах тухай хуулиар тогтоосон “байх ёстой” үзүүлэлт практикт хэр байгааг илрүүлэх зорилготой. Хуульд байвал зохих тодорхой үзүүлэлтийг зааж өгсөн тохиолдолд одоо байгаа үзүүлэлттэй харьцуулна.
2	Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойш	Далай ашиглах тухай хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнө Монгол Улс далайн тээврийн салбарт ямар ч үйл ажиллагаа явуулдаггүй байсан бөгөөд хууль хүчин төгөлдөр хэрэгжсэний дараа Засгийн газрын 2003 оны 3 дугаар тогтоолоор “Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд хөлөг онгоц бүртгэх журам” батлагдан хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагаа өнөөг хүртэл хэрэгжиж байна.
3	Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш	Далай ашиглах хууль 1999 оноос хойш хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш Монгол Улс нь далайн салбарын олон улсын олон талт 29 гэрээ конвенцид нэгдэн орж, ОУДБ-ын өмнө тодорхой үүргүүдийг хүлээж ирсэн. Тухайлбал, Монгол Улсын Их Хурлын 2001 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн хуулиар “Далайд хүний аюулгүй байдлыг хангах тухай конвенц”, “Дипломтой далайчдыг бэлтгэх болон ээлжийн ажиллагааны тухай конвенц” болон “Далайг усан онгоцноос бохирдуулахаас сэргийлэх тухай конвенц”-д нэгдэн орсныг соёрхон баталсан.
4	Тохиолдол судлах	Хууль болон үнэлгээний хүрээгээр тогтоогдсон зүйл, заалт өөр орчин нөхцөлд /Азербайжан/ хэрхэн хэрэгжиж

	буй байдлыг харьцуулна.
--	-------------------------

Уг хуулийн 2, 3, 5 дугаар бүлгийн холбогдох зүйлүүдийг хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш болон тохиолдол судлах хэлбэрээр харьцуулан үнэлнэ.

Хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш харьцуулах хэлбэрийн хүрээнд далайн баялаг олборлох, загас агнах, далайн тээвэр хийх, техникийн хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой эрх, үүргийн нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөн, ялангуяа эрх зүйн хамгаалалт сайжирсан эсэхийг судалж тогтооно.

Тохиолдол судлах хэлбэрийн хүрээнд сонгон авсан зохицуулалт гадаадын зарим улс оронд буюу Бүгд Найрамдах Азербайжан Улсад хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар харьцуулж, дүн шинжилгээ хийнэ.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Далай ашиглах тухай хуулийг Бүгд Найрамдах Азербайжан Улсын Худалдааны далайн тээврийн хуультай дараах хүснэгтэд үзүүлсэн байдлаар харьцуулав.

Монгол Улс	Бүгд Найрамдах Азербайжан Улс
<p>7 дугаар зүйл. Техникийн хяналтыг хэрэгжүүлэх</p> <p>7.1.Хөлөг онгоцонд тавих техникийн хяналтыг тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.</p> <p>7.2.Энэ зорилгоор хөлөг онгоцны олон улсын техникийн хяналтын байгууллага, нарийн мэргэшсэн мэргэжлийн бусад байгууллага, шинжээчийг томилно.</p>	<p>Хуулийн 16 дугаар зүйлд хөлөг онгоцны техникийн хяналт, шалгалтын тухай зохицуулсан бөгөөд далайн тээврийн аюулгүй байдал болон Бүгд Найрамдах Азербайжан Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнүүдийн шаардлагад нийцсэн хөлөг онгоцыг аялалд гарахыг зөвшөөрдөг байна.</p> <p>Энэхүү зөвшөөрлийг олон улсын техникийн хяналтын байгууллага хэрэгжүүлдэг бөгөөд арилжааны бус зорилгоор ашиглагддаг спортын болон аяллын хөлөг онгоцнуудаас бусад худалдааны зорилгоор ашиглах хөлөг онгоцонд техникийн хяналт, шалгалтыг хийдэг байна.</p> <p>Өөрөөр хэлбэл, Азербайжан Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэгдэх болон бүртгэлтэй хөлөг онгоцны техникийн хяналт, шалгалтыг олон улсын техникийн хяналтын байгууллага болох Хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагатай гэрээ байгуулсны үндсэн дээр хэрэгжүүлж, гэрчилгээ олгон ажиллахаар зохицуулагдсан байна.</p>
<p>8¹ дүгээр зүйл. Далайн захиргаа</p> <p>8¹.1.Монгол Улсын далайн захиргаа байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын</p>	<p>Хуулийн 5 дугаар зүйл бүхэлдээ Худалдааны далайн тээвэрт төрийн хяналтыг хэрэгжүүлэх бөгөөд тус улсын худалдааны далайн тээврийн төрийн чиг үүргийн хэрэгжүүлэх агентлаг буюу Бүгд Найрамдах Азербайжан улсын Далайн захиргаа хэрэгжүүлэхээр тусгасан.</p> <p>Мөн байгууллагын чиг үүрэгт:</p>

<p>гишүүн Монгол Улсын олон улсын гэрээнд нийцүүлэн шийдвэрлэнэ.</p> <p>8¹.2.Далайн захиргаа нь үйл ажиллагааныхаа орлого болон улсын төсвөөс хуваарилсан хөрөнгөөр санхүүжинэ.</p>	<ul style="list-style-type: none"> - Бүгд Найрамдах Азербайжан Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнүүд болон Бүгд Найрамдах Азербайжан Улсын худалдааны далайн тээврийн талаарх хууль тогтоомжид нийцэж буй эсэх; - хөлөг онгоцны хөдөлгөөнийг аюулгүй удирдах систем, далайн тээврийн маршрутын нөхцөл байдал болон далайн тээврийн маршрутад суурилуулсан навигацийн тоног төхөөрөмжүүд; - хөлөг онгоцны бүртгэл болон холбогдох эрх; - далайн боомт дахь хөлөг онгоцны чиглүүлэгчийн алба болон хөлөг онгоцны хөдөлгөөнийг удирдах систем; - авран хамгаалах ажиллагаа болон бусад аврах ажиллагааны албатай уялдаатай ажиллаж буй байдал; - далайн хүрээлэн буй орчныг хамгаалахад хяналт тавьж, хэрэгжүүлэхийг хуульчилж өгсөн.
<p>11 дүгээр зүйл. Хөлөг онгоцны бүртгэл</p> <p>11.1.Монгол Улсын хөлөг онгоцны Далайн захиргаа нь төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчид байгаа буюу тэдгээрийн түрээслэсэн хөлөг онгоцыг Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэнэ. Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэл нээлттэй байна.</p> <p>11.2.Тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай гэрээ байгуулсан Олон Улсын хөлөг онгоцны техникийн хяналтын байгууллагаар техникийн үзлэг хяналт хийлгэсний дараа хөлөг онгоцыг Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэнэ.</p> <p>11.3.Энэ зүйлийн 11.1-д заасны дагуу бүртгэлд бүртгэгдсэн хөлөг онгоцыг Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн газарт</p>	<p>Хуулийн 3 дугаар бүлэгт 26-40 дүгээр зүйлд Бүгд Найрамдах Азербайжан Улсын хөлөг онгоцны бүртгэл тусгагдсан бөгөөд хөлөг онгоцны бүртгэл болон түүнтэй холбоотой журмыг холбогдох эрх бүхий байгууллага болох Далайн захиргаа батлан хэрэгжүүлдэг байна.</p> <p>Хөлөг онгоцыг бүртгэхдээ хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагаар үзлэг шалгалт хийлгэсэн хөлөг онгоцыг Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэнэ гэж хуулийн 26.5 дахь хэсэгт заасан.</p> <p>Мөн Бүгд Найрамдах Азербайжан Улсын далбаан дор аялах эрх авсан хөлөг онгоцыг тус улсын хөлөг онгоцны түрээсийн бүртгэлд бүртгэх ба харьяалалгүй эсхүл өөр улсын харьяалалтай хөлөг онгоцны эзэмшигчийн хөлөг онгоцыг Бүгд Найрамдах Азербайжан Улсын Хөлөг онгоцны бүртгэлд бүртгэдэггүй байна. Энэ нь хөлөг онгоц бүртгэлийн хаалттай⁶ төрөл юм.</p> <p>Түүнчлэн хөлөг онгоцыг аж ахуйн зориулалтаар хэрэглэх тохиолдолд энэ хуульд заасан тусгайлсан журмын дагуу бүртгэдэг.</p> <p>Уг хуулийн 38 дугаар зүйлд “Улсын хөлөг онгоцны бүртгэлээс хөлөг онгоцыг хасах” тухай дараах байдлаар зохицуулжээ. Үүнд:</p>

⁶ Зөвхөн өөрийн улсын иргэн, хуулийн этгээдийн эзэмшилд байгаа хөлөг онгоцыг улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэхийг зөвшөөрдөг бүртгэлийн хэлбэрийг "уламжлалт" буюу "хаалттай" бүртгэл гэж нэрлэдэг.

<p>бүртгүүлнэ.</p> <p>11.4.Хөлөг онгоцыг хөлөг онгоц эзэмшигч өөрөө хүсэлт гаргасан, ашиглалтаас хассан, өөр улсад шилжүүлсэн, сүүлчийн удаа холбоо тогтоосон өдрөөс хойш гурван сар, дайн, зэвсэгт мөргөлдөөн болж буй бүсэд зургаан сараас дээш хугацаагаар сураггүй алга болсон тохиолдолд Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлээс хасна.</p> <p>11.5.Гадаад улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэлтэй хөлөг онгоцыг дангаар түрээслэх гэрээгээр эзэмшиж байгаа, уг хөлөг онгоц нь зохих мэргэжил боловсрол эзэмшсэн, дадлага туршлагатай багаар хангагдсан бол түүнийг нэг удаагийн аяллын гэрээг үргэлжлүүлэх хугацаанд дангаар түрээсэлсэн хөлөг онгоц гэж үзэж Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэнэ.</p>	<ul style="list-style-type: none"> - Хөлөг онгоц алдагдсан эсхүл устсан; - Ачаа, барааны алдагдал; - Хөлөг онгоцыг сэргээн босгосон эсхүл аливаа өөрчлөлт хийсний улмаас хөлөг онгоц үр өгөөжтэй байдлаа алдсан; - Хэрэв хөлөг онгоц нь ердийн нөхцөлд мэдээлэл өгсөн хугацаанаас хойш хүрэх боомт хүртэл ямар нэгэн мэдээлэл өгөөгүй бол хөлөг онгоцыг алга болсонд тооцно. Хөлөг онгоцыг алга болсонд тооцох хугацаа нь нэг сар хүртэл, хөлөг онгоцноос мэдээлэл авснаас хойш гурав сар хүртэл байна. - Хэрэв хөлөг онгоцыг сэргээх боломжгүй эсхүл хөлөг онгоцыг сэргээн засварлах нь эдийн засгийн хохиролтой бол хөлөг онгоцыг анх хийсэн дизайнаас устсан гэж үзнэ гэх мэт.
<p>22 дугаар зүйл. Далай ашиглах тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага</p> <p>22.1.Далай ашиглах тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу зохих хариуцлага хүлээлгэнэ.</p>	<p>Хуулийн 26 дугаар бүлэг бүхэлдээ хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын талаар байгаа бөгөөд 12 зүйл, 22 заалтаар зохицуулж өгсөн байна. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> - Энэхүү хууль тогтоомжийн зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага - Хөлөг онгоцыг эзэмших эрх болон бусад эд хөрөнгийн ашиг сонирхол зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага - Хөлөг онгоцны багийн гишүүдийн стандартыг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага - Худалдааны далайн тээврийн чиглэлээр байгуулсан гэрээнээс үүдэн гарах хариуцлага - Хөлөг онгоц мөргөлдсөнөөс үүдэн гарах хариуцлага - Хөлөг онгоцноос ялгаран гарсан газрын тосны бохирдлоос үүдэлтэй хариуцлага - Далайд аюултай, хортой бодис

	<p>тээвэрлэснээс үүдэлтэй хариуцлага</p> <ul style="list-style-type: none"> – Хөлөг онгоц эзэмшигчийн үүрэг хариуцлагын хязгаарлалт – Бүгд Найрамдах Азербайжан Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тодорхой тусгаж өгсөн байна.
--	---

1.5. Шалгуур үзүүлэлт тодорхойлох

Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

1. Хуулийн хоёрдугаар бүлэг. Далай ашиглах үйл ажиллагаа

- Хуулийн 7 дугаар зүйл буюу хөлөг онгоцонд тавих техникийн хяналтыг хэрэгжүүлэх тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зохицуулалт зорилгодоо хэр хүрсэн бэ гэдгийг тодорхойлно.
- Хуулийн 8¹ дүгээр зүйл буюу Монгол Улсын Далайн захиргааны эрх зүйн байдал зорилгодоо хэр хүрсэн бэ гэдгийг тодорхойлно.

2. Хуулийн гуравдугаар бүлэг. Хөлөг онгоцны бүртгэл

- Хуулийн 11 дүгээр зүйл буюу Далайн захиргаа нь төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчид байгаа буюу тэдгээрийн түрээслэсэн хөлөг онгоцыг Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэх зохицуулалт зорилгодоо хэр хүрсэн бэ гэдгийг тодорхойлно.

3. Хуулийн тавдугаар бүлэг. Бусад зүйл

- Хуулийн 22 дугаар зүйл буюу Далай ашиглах тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлох эрх зүйн үндсийг бүрэн тавьж чадаж байгаа болон хүлээлгэж буй хариуцлага нь хуулийн зорилгыг хангаж байгаа эсэхийг тодруулахад оршино.

Практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

1. Хуулийн хоёрдугаар бүлэг. Далай ашиглах үйл ажиллагаа

- Хуулийн 7 дугаар зүйл буюу хөлөг онгоцонд тавих техникийн хяналтыг хэрэгжүүлэх тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зохицуулалт практикт нийцэж байна уу, хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлно.
- Хуулийн 8¹ дүгээр зүйл буюу Далайн захиргааны эрх зүйн байдал практикт нийцэж байна уу, хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлно.

2. Хуулийн гуравдугаар бүлэг. Хөлөг онгоцны бүртгэл

- Хуулийн 11 дүгээр зүйл буюу Далайн захиргаа нь төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчид байгаа буюу тэдгээрийн түрээслэсэн хөлөг онгоцыг Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэх зохицуулалт практикт нийцэж байна уу, хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлно.

3. Хуулийн тавдугаар бүлэг. Бусад зүйл

- Хуулийн 22 дугаар зүйл хэрэгжиж байна уу, хэрэгжилтэд хүндрэл гарч байгаа эсэх, хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэж буй хариуцлага хэр бодитой байна вэ гэдгийг тодорхойлно.

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Үнэлгээ хийх шалтгаан, үнэлгээ хийх хүрээ, шалгуур үзүүлэлт, сонгосон харьцуулах хэлбэр, томъёолсон шалгуур үзүүлэлт зэргийг харгалзан ямар мэдээлэл олж авахаа тодорхойлж, уг мэдээллийг ямар аргаар хэзээ, хаанаас цуглуулахаа сонгож, шаардлагатай материалыг дараах аргаар цуглуулсан болно.

Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах: Далай ашиглахтай холбогдох Монгол Улсын болон гадаадын зарим орны хууль тогтоомж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенциуд,

Холбогдох субъектээс судалгаа авах: Олон улсын далайн байгууллага (ОУДБ)-аас 2016 онд Монгол Улс далбааны эзэн улсын эрх үүргээ хэрхэн хэрэгжүүлж буй байдалд хийсэн аудитын шалгалтын тайлан, зөвлөмж

Төлөвлөх үе шатанд хийгдсэн ажлыг хүснэгтээр харуулбал:

ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Үнэлгээний хүрээ	Шалгуур үзүүлэлт	Харьцуулах хэлбэр	Шалгуур үзүүлэлтийн томъёолол	Мэдээлэл цуглуулах арга
<p>Хуулийн 2 дугаар бүлэг. Далай ашиглах үйл ажиллагаа ✓ 7 дугаар зүйл. Техникийн хяналтыг хэрэгжүүлэх ✓ 8¹ дүгээр зүйл. Далайн захиргаа</p>	<ul style="list-style-type: none"> • Зорилтод хүрсэн түвшин • Практикт нийцэж байгаа байдал 	<ul style="list-style-type: none"> • Тохиолдол судлах • Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш 	<p>Зорилгод хүрсэн түвшин</p> <ul style="list-style-type: none"> • Хуулийн 7, 8¹ дүгээр зүйлийн зохицуулалт зорилгодоо хэр хүрсэн бэ? <p>Практикт нийцэж байгаа байдал</p> <ul style="list-style-type: none"> • Хуулийн 7, 8¹ дүгээр зүйлийн зохицуулалт практикт нийцэж байна уу, хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэх? 	<ul style="list-style-type: none"> • Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах • Холбогдох субьектээс судалгаа авах
<p>Хуулийн 3 дугаар бүлэг. Хөлөг онгоцны бүртгэл ✓ 11 дүгээр зүйл. Хөлөг онгоцны бүртгэл</p>	<ul style="list-style-type: none"> • Зорилтод хүрсэн түвшин • Практикт нийцэж байгаа байдал 	<ul style="list-style-type: none"> • Тохиолдол судлах • Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш 	<p>Зорилгод хүрсэн түвшин</p> <ul style="list-style-type: none"> • Хуулийн 11 дүгээр зүйлийн зохицуулалт зорилгодоо хэр хүрсэн бэ? <p>Практикт нийцэж байгаа байдал</p> <ul style="list-style-type: none"> • Хуулийн 11 дүгээр зүйлийн зохицуулалт практикт нийцэж байна уу, хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэх? 	<ul style="list-style-type: none"> • Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах • Холбогдох субьектээс судалгаа авах
<p>Хуулийн 5 дугаар бүлэг. Бусад ✓ 22 дугаар зүйл. Далай ашиглах тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага</p>	<ul style="list-style-type: none"> • Зорилтод хүрсэн түвшин • Практикт нийцэж байгаа байдал 	<ul style="list-style-type: none"> • Тохиолдол судлах • Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш 	<p>Зорилгод хүрсэн түвшин</p> <ul style="list-style-type: none"> • Хуулийн 22 дугаар зүйлийн зохицуулалт зорилгодоо хэр хүрсэн бэ? <p>Практикт нийцэж байгаа байдал</p> <ul style="list-style-type: none"> • Хуулийн 22 дугаар зүйлийн зохицуулалт практикт нийцэж байна уу, хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэж буй хариуцлага хэр бодитой байна вэ? 	<ul style="list-style-type: none"> • Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах • Холбогдох субьектээс судалгаа авах

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

2.1. Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах

2.1.1. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенциуд

- Далайд гарцгүй улсуудын далбаагаа мандуулах эрхийг хүлээн зөвшөөрсөн Барселоны 1921 оны тунхаглал, Монгол Улс 1976 оны 10 дугаар сарын 15-ны өдөр нэгдэн орсон;
- “Транзит худалдааны тухай” олон улсын конвенц (1965 он), Монгол Улс 1975 онд нэгдэн орсон.
- “Далайн эрх зүйн тухай” НҮБ-ын конвенц (1982 он), Монгол Улс 1996 оны 05 дугаар сарын 28-ны өдөр нэгдэн орсон;
- “Олон Улсын Далайн Байгууллагын тухай” олон улсын конвенцийн нэмэлт өөрчлөлт (1948 он), Монгол Улс 1996 оны 05 дугаар сарын 28-ны өдөр нэгдэн орсон;
- “Олон Улсын Далайн Байгууллагын тухай” олон улсын конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протокол (1991 он), Монгол Улс 2007 оны 05 дугаар сарын 04-ний өдөр нэгдэн орсон;
- “Олон Улсын Далайн Байгууллагын тухай” олон улсын конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протокол (1993 он), Монгол Улс 2008 оны 08 дугаар сарын 17-ны өдөр нэгдэн орсон;
- "Хөлөг онгоцноос үүдэлтэй бохирдлоос сэргийлэх тухай" олон улсын конвенц (1973 он), Монгол Улс 2004 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр нэгдэн орсон;
- "Хөлөг онгоцноос үүдэлтэй бохирдлоос сэргийлэх тухай" олон улсын конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулсан протокол (1973 он), Монгол Улс 2007 оны 05 дугаар сарын 04-ний өдөр нэгдэн орсон;
- "Хөлөг онгоцноос үүдэлтэй бохирдлоос сэргийлэх тухай" олон улсын конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулсан протокол (1997 он), Монгол Улс 2007 оны 05 дугаар сарын 04-ний өдөр нэгдэн орсон;
- "Далайд хүний аюулгүй байдлыг хангах тухай" олон улсын конвенц (1974 он), Монгол Улс 2001 оны 12 дугаар сарын 24-ний өдөр нэгдэн орсон;
- "Далайд хүний аюулгүй байдлыг хангах тухай" олон улсын конвенцийн протокол (1988 он), Монгол Улс 2007 оны 05 дугаар сарын 04-ний өдөр нэгдэн орсон;
- "Далайд хүний аюулгүй байдлыг хангах тухай" олон улсын конвенцийн протокол (1978 он), Монгол Улс 2008 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр нэгдэн орсон;

- "Дипломтой далайчдыг бэлтгэх болон ээлжийн ажиллагааны тухай" (1978 он), Монгол Улс 2002 оны 12 дугаар сарын 14-ний өдөр нэгдэн орсон;
- "Далайд хөлөг онгоц мөргөлдөхөөс урьдчилан сэргийлэх олон улсын журмын тухай" олон улсын конвенц (1972 он), Монгол Улс 2001 оны 12 дугаар сарын 14-ний өдөр нэгдэн орсон;
- "Хөлөг онгоцны багтаамжийн хэмжилтийн тухай" олон улсын конвенц (1969 он), Монгол Улс 2002 оны 09 дүгээр сарын 26 -ны өдөр нэгдэн орсон;
- "Даацын тэмдэглэгээний тухай" олон улсын конвенц (1966 он), Монгол Улс 2003 оны 06 дугаар сарын 03-ны өдөр нэгдэн орсон;
- "Даацын тэмдэглэгээний тухай" олон улсын конвенц нэмэлт өөрчлөлтийн протокол (1988 он), Монгол Улс 2007 оны 05 дугаар сарын 04-ний өдөр нэгдэн орсон;
- Олон улсын хөдөлмөрийн байгууллагын "Далайн хөдөлмөрийн тухай" олон улсын конвенц (2006 он), Монгол Улс 2014 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр нэгдэн орсон;
- "Газрын тосны бохирдлоос учирсан хохирлын төлөөх хүлээх иргэний хариуцлагын тухай" олон улсын конвенц (1969 он), Монгол Улс 2003 оны 07 сарын 01-ний өдөр нэгдэн орсон;
- "Газрын тосны бохирдлоос учирсан хохирлын төлөөх хүлээх иргэний хариуцлагын тухай" олон улсын конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протокол (1992 он), Монгол Улс 2008 оны 08 дугаар сарын 08-ны өдөр нэгдэн орсон;
- "Хөлөг онгоцны шатахууны савны тосны бохирдлоос учирсан хохирлын төлөө хүлээх иргэний хариуцлагын тухай" олон улсын конвенц (2001 он), Монгол Улс 2011 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр нэгдэн орсон;
- "Хөлөг онгоцны гадаргууг хамгаалах системд хортой бодис ашиглахыг хянах тухай" олон улсын конвенц (2001 он), Монгол Улс 2011 оны 12 дугаар сарын 07-ны өдөр нэгдэн орсон;
- "Хөлөг онгоцны тэнцвэржүүлэгч ус болон үлдэгдэл тунадасны хяналт ба менежментийн тухай" олон улсын конвенц (2004 он), Монгол Улс 2011 оны 12 дугаар сарын 11-ний өдөр нэгдэн орсон;
- "Далайн нэхэмжлэлийн талаар хүлээх хариуцлагыг хязгаарлах тухай" олон улсын конвенц (1976 он), Монгол Улс 2012 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр нэгдэн орсон;

- Далайн нэхэмжлэлийн талаар хүлээх хариуцлагыг хязгаарлах тухай конвенцийн протокол (1996 он), Монгол Улс 2011 оны 12 дугаар сарын 27-ны өдөр нэгдэн орсон;
- Далайн хиймэл дагуулын олон улсын байгууллагын конвенц (1979 он), Монгол Улс 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдөр нэгдэн орсон;
- Аврах ажиллагааны тухай олон улсын конвенц (1989 он), Монгол Улс 2014 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр нэгдэн орсон;
- Далайн хөдөлмөрийн тухай олон улсын конвенц (2006 он), Монгол Улс 2014 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр нэгдэн орсон;
- Далайн навигацын аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай олон улсын конвенц (1988 он), Монгол Улс 2005 оны 08 дугаар сарын 04-ний өдөр нэгдэн орсон.

2.1.2. Хууль тогтоомж

- Далай ашиглах тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Зөрчлийн тухай хууль
- Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль
- Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль

2.1.3. Гадаад улс орны хуулиуд

- Бүгд Найрамдах Азербайжан улсын Далайн худалдааны тээврийн тухай хууль
- Бүгд Найрамдах Казахстан улсын Далайн тээврийн тухай хууль

2.2. Холбогдох субъектээс судалгаа авах

- Олон улсын далайн байгууллага (ОУДБ)-аас 2016 онд Монгол Улс далбааны эзэн улсын эрх үүргээ хэрхэн хэрэгжүүлж буй байдалд хийсэн аудитын шалгалтын тайлан, зөвлөмж.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Далай ашиглах тухай хууль нь 1999 онд батлагдсанаас хойш 19 жил өнгөрчээ. Түүнээс хойш нэг удаа буюу 2007 онд нэмэлт өөрчлөлт орсон байна. Энэ хугацаанд хуулийн хэрэгжилтийн талаар судалгаа хийгдэж байгаагүй байна. Гэсэн хэдий ч энэ хуулийн хэрэгжилттэй холбоотой зарим тулгамдсан асуудал тухайлбал, хөлөг онгоцонд тавих техникийн хяналт хэрэгжүүлэх болон хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагаанд хүндрэл бэрхшээлтэй асуудал гарч байна.

Иймээс энэхүү үнэлгээний ажилд сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна.

3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Далай ашиглах тухай хуулийн үндсэн зорилтыг “Монгол Улсын Төрийн далбаа мандуулсан хөлөг онгоцоор далайн баялаг олборлох, загас агнах, тээвэр хийх зэрэг далай ашиглах үйл ажиллагаа явуулах, далай дахь аюулгүй байдлыг хангах, далайн орчныг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” хэмээн уг хуулийн нэгдүгээр зүйлд заасан байна. Иймд уг хуулийн бүхий л зохицуулалт энэхүү үндсэн зорилтыг хангахад чиглэн үйлчлэх учиртай.

Энэхүү зорилгыг хангах хүрээнд Далай ашиглах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 болон 7.2 дахь хэсгийн зохицуулалтыг хуульчилсан байна.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. Хуулийн 7 болон 8¹ дүгээр зүйл буюу хөлөг онгоцонд тавих техникийн хяналтыг хэрэгжүүлэх тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зохицуулалт болон Монгол Улсын далайн захиргааны эрх зүйн байдал зорилгодоо хэр хүрсэн бэ?

7 дугаар зүйл. Техникийн хяналтыг хэрэгжүүлэх

7.1. Хөлөг онгоцонд тавих техникийн хяналтыг тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

7.2. Энэ зорилгоор хөлөг онгоцны олон улсын техникийн хяналтын байгууллага, нарийн мэргэшсэн мэргэжлийн бусад байгууллага, шинжээчийг томилно.

Хуулийн 7.1 дэх хэсэг нь хуулийн үндсэн зорилтыг хангахад нөлөө үзүүлэх чухал зохицуулалт боловч бодит байдал дээр тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь захиргааны акт гарган уг асуудлыг хэрэгжүүлэх хуулийн 11.2-т заасан эрхээ Далайн захиргаанд шилжүүлэн ажиллаж байна. Харин Далайн захиргаа нь хуулийн 7.2-т заасны дагуу Монгол улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэлтэй хөлөг онгоцонд техникийн хяналт, шалгалт хийх үүрэг бүхий Хүлээн зөвшөөрөгдсөн байгууллага /ангиллын нийгэмлэг/ -тай гэрээ байгуулан ажиллан, хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлж байна.

8¹ дүгээр зүйл. Далайн захиргаа

8¹.1. Монгол Улсын далайн захиргаа байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Монгол Улсын олон улсын гэрээнд нийцүүлэн шийдвэрлэнэ.

/Дээрх 8¹ дүгээр зүйлийг 2007 оны 8 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмсэн/

Далайд хүний аюулгүй байдлыг хангах тухай олон улсын конвенц⁷, Дипломтой далайчдыг бэлтгэх болон ээлжийн ажиллагааны тухай конвенц⁸ болон Далайг усан онгоцноос бохирдуулахаас сэргийлэх тухай конвенцид⁹ “Аливаа улсын далбаан дор үйл ажиллагаагаа явуулах эрх бүхий хөлөг онгоцны хувьд захиргаа /Maritime Administration/ нь тухайн улсын Засгийн газар байна” гэж тодорхойлсон байдаг.

Засгийн газрын үйл ажиллагааны тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэх үүднээс Далай ашиглах тухай хуульд 2007 онд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан Монгол Улсын Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын 2007 оны 174 дүгээр тушаалаар далай ашиглах үйл ажиллагаа явуулах, далай дахь аюулгүй байдлыг хангах, далайн орчныг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэх Монгол Улсын далайн захиргааг байгуулсан.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2. Хуулийн 11 дүгээр зүйл буюу Далайн захиргаа нь төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчид байгаа буюу тэдгээрийн түрээслэсэн хөлөг онгоцыг Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэх зохицуулалт зорилгодоо хэр хүрсэн бэ?

11 дүгээр зүйл. Хөлөг онгоцны бүртгэл

11.1. Монгол Улсын Далайн захиргаа нь төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчид байгаа буюу тэдгээрийн түрээслэсэн хөлөг онгоцыг Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэнэ. Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэл нээлттэй байна.

11.2. Тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай гэрээ байгуулсан Олон Улсын хөлөг онгоцны техникийн хяналтын байгууллагаар техникийн үзлэг хяналт хийлгэсний дараа хөлөг онгоцыг Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэнэ.

11.3. Энэ зүйлийн 11.1-д заасны дагуу бүртгэлд бүртгэгдсэн хөлөг онгоцыг Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн газарт бүртгүүлнэ.

1.4. Хөлөг онгоцыг хөлөг онгоц эзэмшигч өөрөө хүсэлт гаргасан, ашиглалтаас хассан, өөр улсад шилжүүлсэн, сүүлчийн удаа холбоо тогтоосон өдрөөс хойш гурван сар, дайн, зэвсэгт мөргөлдөөн болж буй бүсэд зургаан сараас дээш хугацаагаар сураггүй алга болсон тохиолдолд Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлээс хасна.

⁷ Монгол Улсын Их Хурлын 2001 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн хуулиар “Далайд хүний аюулгүй байдлыг хангах тухай конвенц”-д нэгдэн орсныг соёрхон баталсан.

⁸ Монгол Улсын Их Хурлын 2001 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн хуулиар “Дипломтой далайчдыг бэлтгэх болон ээлжийн ажиллагааны тухай конвенц”-д нэгдэн орсныг соёрхон баталсан.

⁹ Монгол Улсын Их Хурлын 2001 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн хуулиар “Далайг усан онгоцноос бохирдуулахаас сэргийлэх тухай конвенц”-д нэгдэн орсныг соёрхон баталсан.

11.5. Гадаад улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэлтэй хөлөг онгоцыг дангаар түрээслэх гэрээгээр эзэмшиж байгаа, уг хөлөг онгоц нь зохих мэргэжил боловсрол эзэмшсэн, дадлага туршлагатай багаар хангагдсан бол түүнийг нэг удаагийн аяллын гэрээг үргэлжлүүлэх хугацаанд дангаар түрээсэлсэн хөлөг онгоц гэж үзэж Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэнэ.

Хуулийн 11.1-т заасан зохицуулалт нь хуулийн зорилтыг хангахад нийцэж байна. Засгийн газрын 2003 оны 3 дугаар тогтоолоор “Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд хөлөг онгоц бүртгэх журам” батлагдаж, улмаар 2003 онд Монгол-Сингапурын хамтарсан “Монголын хөлөг онгоцны бүртгэл” ХХК байгуулагдсанаар Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагаа өнөөг хүртэл хэрэгжиж байна.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 3. Хуулийн 22 дугаар зүйл буюу Далай ашиглах тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлох эрх зүйн үндсийг бүрэн тавьж чадаж байгаа болон хүлээлгэж буй хариуцлага нь хуулийн зорилгыг хангаж байгаа эсэх?

22 дугаар зүйл. Далай ашиглах тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

22.1. Далай ашиглах тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу зохих хариуцлага хүлээлгэнэ.

Уг зүйлээр Далай ашиглах тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлсон ба хуулийн үндсэн зорилтод ерөнхийдөө нийцсэн боловч ямар төрлийн зөрчилд, хэн хариуцлага хүлээлгэх нь тодорхой биш байна.

3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. Хуулийн 7, 8¹ дүгээр зүйл буюу хөлөг онгоцонд тавих техникийн хяналтыг хэрэгжүүлэх тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зохицуулалт болон Монгол Улсын далайн захиргааны эрх зүйн байдал практикт нийцэж байна уу, хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэх?

7 дугаар зүйл. Техникийн хяналтыг хэрэгжүүлэх

7.1. Хөлөг онгоцонд тавих техникийн хяналтыг тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

7.2. Энэ зорилгоор хөлөг онгоцны олон улсын техникийн хяналтын байгууллага, нарийн мэргэшсэн мэргэжлийн бусад байгууллага, шинжээчийг томилно.

Далай ашиглах тухай хуулийн 7 дугаар зүйлд “Техникийн хяналтыг хэрэгжүүлэх” талаар зохицуулсан бөгөөд төрийн захиргааны төв байгууллага хөлөг онгоцонд тавих техникийн хяналт хийх эсхүл олон улсын техникийн хяналтын байгууллага, нарийн мэргэшсэн мэргэжлийн бусад байгууллага, шинжээчийг томилох гэж заасан боловч өнөөгийн байдлаар төрийн захиргааны төв байгууллага нь захиргааны акт гарган Далайн захиргаанд эрхээ шилжүүлж, улмаар Далайн захиргаа нь Далай ашиглах тухай 9.1.2-т “хөлөг онгоцны байгууламж, хөдөлгүүр, бусад тоног төхөөрөмжид техникийн хяналт тавих” гэж заасан чиг үүргээ мөн хуулийн 9.2-т “Далайн захиргаа олон улсын холбогдох эрх бүхий мэргэжлийн байгууллагатай гэрээ, хэлцэл байгуулсны үндсэн дээр хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэлтэй хөлөг онгоцнуудад техникийн хяналт шалгалт явуулахын тулд хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж байна.

8¹ дүгээр зүйл. Далайн захиргаа

8¹.1. Монгол Улсын далайн захиргаа байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Монгол Улсын олон улсын гэрээнд нийцүүлэн шийдвэрлэнэ.

/Дээрх 8¹ дүгээр зүйлийг 2007 оны 8 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмсэн/

Одоогоор Монгол Улсын Далайн захиргаа нь тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх ажлын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, ажлаа түүнд тайлагнадаг болно.

Далайн захиргааны үйл ажиллагаа явуулах үндсэн чиглэлүүд нь дараах байдалтай байна. Үүнд:

1. Олон улсын болон дотоодын хууль, тогтоомжийн хэрэгжилт;
2. Хөлөг онгоцны бүртгэл, хяналт;
3. Далайн тээвэр;
4. Боомт ашиглалт;
5. Усан замын тээврийн бүртгэл, хяналт;
6. Далайн салбарын үндэсний боловсон хүчин бэлтгэх.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2. Хуулийн 11 дүгээр зүйл буюу Далайн захиргаа нь төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчид байгаа буюу тэдгээрийн түрээслэсэн хөлөг онгоцыг Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэх зохицуулалт практикт нийцэж байна уу, хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэх?

11 дүгээр зүйл. Хөлөг онгоцны бүртгэл

11.1. Монгол Улсын Далайн захиргаа нь төр, иргэн, аж ахуйн нэгж,

байгууллагын өмчид байгаа буюу тэдгээрийн түрээслэсэн хөлөг онгоцыг Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэнэ. Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэл нээлттэй байна.

11.2. Тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай гэрээ байгуулсан Олон Улсын хөлөг онгоцны техникийн хяналтын байгууллагаар техникийн үзлэг хяналт хийлгэсний дараа хөлөг онгоцыг Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэнэ.

11.3. Энэ зүйлийн 11.1-д заасны дагуу бүртгэлд бүртгэгдсэн хөлөг онгоцыг Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн газарт бүртгүүлнэ.

1.4. Хөлөг онгоцыг хөлөг онгоц эзэмшигч өөрөө хүсэлт гаргасан, ашиглалтаас хассан, өөр улсад шилжүүлсэн, сүүлчийн удаа холбоо тогтоосон өдрөөс хойш гурван сар, дайн, зэвсэгт мөргөлдөөн болж буй бүсэд зургаан сараас дээш хугацаагаар сураггүй алга болсон тохиолдолд Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлээс хасна.

11.5. Гадаад улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэлтэй хөлөг онгоцыг дангаар түрээслэх гэрээгээр эзэмшиж байгаа, уг хөлөг онгоц нь зохих мэргэжил боловсрол эзэмшсэн, дадлага туршлагатай багаар хангагдсан бол түүнийг нэг удаагийн аяллын гэрээг үргэлжлүүлэх хугацаанд дангаар түрээсэлсэн хөлөг онгоц гэж үзэж Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэнэ.

Монгол Улс хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагааг 2003 оноос эхлэн хэрэгжүүлж байгаа бөгөөд өнөөдрийг хүртэл Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд 30 гаруй улсын 3500 орчим хөлөг онгоцыг бүртгэж, тогтмол 260 орчим хөлөг онгоц бүртгэлтэй байна. Түүнчлэн хөлөг онгоцыг бүртгэхдээ Монгол Улсын нэрийн өмнөөс техникийн үзлэг шалгалт хийх үүрэг бүхий хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагаар гэрчилгээжүүлсэн хөлөг онгоцыг бүртгэдэг тул хуулийн 11.2 дахь заалт практикт нийцэж байна.

Хөлөг онгоцны бүртгэл нь түр бүртгэлийн буюу 3-6 сар, байнгын бүртгэл буюу 1 жилийн хугацаатай байдаг. Мөн хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагаа нь Монгол Улсын нутаг дэвсгэрт явагддаггүй тул практик дээр уг хуулийн 11.4 дэх заалтыг хэрэгжүүлэх боломж бололцоо хомс байдаг ба өнөөг хүртэл бүртгэлд бүртгэгдсэн хөлөг онгоцыг Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн газарт бүртгүүлж байгаагүй. Хэрэв Монгол Улсын аж ахуй нэгж, иргэний эзэмшлийн хөлөг онгоцыг бүртгэсэн тохиолдолд уг заалт хэрэгжих боломжтой юм.

Монгол Улс хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагааг эхэлснээс хойш хуулийн 11.5-д заагдсан бүртгэлийн төрөл хийгдээгүй болно.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 3. Хуулийн 22 дугаар зүйл хэрэгжиж байна уу, хэрэгжилтэд хүндрэл гарч байгаа эсэх, хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэж буй хариуцлага хэр бодитой байна вэ?

22 дугаар зүйл. Далай ашиглах тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

22.1. Далай ашиглах тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу зохих хариуцлага хүлээлгэнэ.

Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэлтэй хөлөг онгоцны техникийн хяналтын асуудлаар боомтын эрх бүхий байгууллагын шалгалтаар саатуулагдсан тохиолдолд л “Монголын хөлөг онгоцны бүртгэл” компанийн дотоод журмаар торгуулийн арга хэмжээ авч хэрэгжүүлж ирсэн.

Далай ашиглах үйл ажиллагаа болон хөлөг онгоцны бүртгэл нь Монгол Улсын хилийн гадна явагддаг тул хуулийн 22 дугаар зүйлийг хэрэгжүүлэхэд ямар төрлийн зөрчилд, хэн хариуцлага хүлээлгэх, шийтгэлийн төрөл, хэмжээ нь тодорхой биш байдгаас практикт бодитой хэрэгжиж чаддаггүй.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын дагуу Далай ашиглах тухай хууль дахь сонгосон зүйл, заалтад үнэлгээ хийж гүйцэтгэв. Үнэлгээний төгсгөлд үнэлгээг илэрхийлсэн дүгнэлт болон үнэлгээнд тулгуурлан хууль тогтоомжийн хүртээмжтэй, үр нөлөөтэй байдлыг нэмэгдүүлэх талаар зөвлөмж гаргасан болно.

4.1. Үнэлгээний дүгнэлт

Далай ашиглах тухай хуулийн 2, 3, 5 дугаар бүлгийн холбогдох зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаварт “Зорилгод хүрсэн түвшин”, “Практикт хэрэгжсэн байдал” шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийв.

Үнэлгээний үр дүнг зүйл, заалт бүрээр дүгнэхэд дараах байдалтай байна:

7 дугаар зүйл. Техникийн хяналтыг хэрэгжүүлэх.

Зорилгод хүрсэн түвшин:

Хуулийн зорилгод нийцэж байна. Хуулийн 7 дугаар зүйлийн техникийн хяналтыг хэрэгжүүлэх зохицуулалт нь хэт ерөнхий бөгөөд төрийн захиргааны төв байгууллага, эрх бүхий байгууллага, хүлээн зөвшөөрөгдсөн байгууллага, хөлөг онгоц эзэмшигч тэдгээрийн хоорондын харилцаа, чиг үүрэг зэрэг зохицуулалтыг нь дэлгэрүүлж, илүү тодорхой болгох шаардлагатай.

Практикт хэрэгжсэн байдал:

Хөлөг онгоцны олон улсын техникийн хяналтын байгууллага, нарийн мэргэшсэн мэргэжлийн бусад байгууллага, шинжээчийн эрх хэмжээ, чиг үүрэг,

санхүүжүүлэх зарчим, үйл ажиллагааны журам зэрэг нь тодорхой хуульчлагдаагүйгээс гэрээ байгуулсны үндсэн дээр үйл ажиллагаа явуулж байна.

8¹ дүгээр зүйл. Далайн захиргаа.

Зорилгод хүрсэн түвшин:

Засгийн газрын үйл ажиллагааны далайн салбарын тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Далайн захиргаа нь Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд ажиллаж, Монгол Улсын хууль, тогтоомж, далайн салбарын олон улсын гэрээ, конвенцийн хэм хэмжээнд нийцүүлэн далайн тээврийн аюулгүй байдлыг хангах, хүрээлэн буй орчныг бохирдуулахгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлэх, хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагаа явуулах, далайн тээврийн аюулгүй байдлыг хангах, хяналт шалгалт явуулах, далбааны эзэн улсын эрх, үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Мөн далайн чиглэлээр дотоод, гадаадын холбогдох байгууллагатай хамтарсан сургалт зохион байгуулах, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх үйл ажиллагааг олон улсын эрх бүхий байгууллага, гадны улсын ижил түвшний байгууллагатай гэрээ, хэлцэл, санамж бичиг байгуулсны үндсэн дээр хэрэгжүүлж байна.

Практикт хэрэгжсэн байдал:

Далай ашиглах тухай хуулийн 8¹ дүгээр зүйлийн 8¹.1-т заасны дагуу Далайн захиргааг байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэрлэж байна. Мөн хуулийн 8¹ дүгээр зүйлийн 8¹.2-т “Далайн захиргаа нь үйл ажиллагааныхаа орлого болон улсын төсвөөс хуваарилсан хөрөнгөөр санхүүжнэ” гэж заасан нь практикт Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуультай дараах байдлаар зөрчилдөж байна. Үүнд:

1. Далайн захиргаа нь улсын төсвийн хөрөнгөөр санхүүждэггүй, харин улсын төсөвт орлого төвлөрүүлдэг боловч Төрийн санд нэгдсэн дансгүй ба хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагааныхаа орлогоосоо санхүүжиж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “Төрийн өмчит үйлдвэрийн газраас бусад улсын төсвөөс санхүүждэг хуулийн этгээдийг төрийн байгууллага, албан газар гэнэ” гэж заасантай зөрчилдөж “төрийн байгууллага, албан газар” гэсэн энэхүү тодорхойлолтод хамаарахгүй байгаа юм.

2. Далайн захиргааны үйл ажиллагаа нь аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын зарчмаар явагдаж байгаа боловч тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байгууллагын удирдлагыг томилох, бүтэц, орон тооны хязгаарыг тогтоож байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 5-т “аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захиргааны албан тушаалын жагсаалт, орон тооны нормативыг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтооно” гэж заасантай нийцэхгүй байх

тул мөн л “төрийн өмчит үйлдвэрийн газар” гэсэн тодорхойлолтод хамаарахгүй байгаа юм.

Иймд Засгийн газрын үйл ажиллагааны далайн салбарын чиг үүргийг хэрэгжүүлэх эрх бүхий төрийн байгууллагын эрх зүйн байдлыг тодорхой болгох шаардлагатай байна.

11 дүгээр зүйл. Хөлөг онгоцны бүртгэл.

Зорилгод хүрсэн түвшин:

Хуулийн зорилгод нийцсэн байна. Хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагааг 2003 онд Монгол Улсын Далайн захиргаа Сингапурын талын хувийн хэвшлийн төлөөлөлтэй хамтарсан “Монголын хөлөг онгоцны бүртгэл” компанийг Сингапур улсад байгуулагдсанаар Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагаа өнөөг хүртэл хэрэгжиж байна.

Практикт хэрэгжсэн байдал:

Өнөөг хүртэл Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд 30 гаруй улсын 3500 орчим хөлөг онгоцыг бүртгэсэн ба одоогоор тогтмол 260 орчим хөлөг онгоц бүртгэлтэй байна. Хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагаар техникийн үзлэг шалгалт хийлгэн гэрчилгээжсэн хөлөг онгоцыг бүртгэлд бүртгэж байгаа нь хуулийн хөлөг онгоц бүртгэхтэй холбогдсон зохицуулалт нь ерөнхийдөө практикт нийцэж байна.

Хөлөг онгоцны бүртгэлийн хугацаанаас хамааран хөлөг онгоцыг Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн газарт бүртгүүлдэггүй бөгөөд хэрэв Монгол Улсын аж ахуй нэгж, иргэний эзэмшлийн хөлөг онгоцыг бүртгэсэн тохиолдолд уг заалт хэрэгжих боломжтой юм.

22 дугаар зүйл. Далай ашиглах тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага.

Зорилгод хүрсэн түвшин:

Хуулийн зорилгод нийцсэн байна. Гэхдээ хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т “Далай ашиглах тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу зохих хариуцлага хүлээлгэнэ” гэсэн нь ямар зөрчилд, хэн хариуцлага хүлээлгэх, шийтгэлийн төрөл, хэмжээ нь тодорхой биш байна.

Практикт хэрэгжсэн байдал:

Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэлтэй хөлөг онгоцны техникийн хяналтын асуудлаар боомтын эрх бүхий байгууллагын шалгалтаар саатуулагдсан тохиолдолд л “Монголын хөлөг онгоцны бүртгэл” компанийн дотоод журмаар торгуулийн арга хэмжээ авч хэрэгжүүлж ирсэн байна.

Мөн Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэлтэй хөлөг онгоцонд НҮБ-аас хориг тавьсан тохиолдолд бүртгэлээс нэн даруй хасах арга хэмжээ авдаг.

Хууль мөрдөгдсөнөөс хойш далай ашиглахтай холбогдсон хууль тогтоомж зөрчсөн шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг байхгүй байна.

4.2. Зөвлөмж

Үнэлгээний үр дүнд буюу үнэлгээг илэрхийлсэн дүгнэлтэд тулгуурлан хууль тогтоомжийн хэрэгжилтийг илүү өндөр хүртээмжтэй, үр нөлөөтэй болгох талаар дараах санал зөвлөмж гаргаж байна.

Далай ашиглах тухай хуулийн холбогдох бүлэг, зүйл, заалтад хийсэн дээр дурдсан дүгнэлтэд үндэслэн, ажлын хэсгийн зүгээс Далай ашиглах тухай хуулийг шинэчлэн найруулах, мөн хуулийн төсөлтэй хамт Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Далай ашиглах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг тус тус боловсруулахаар санал гаргаж байна. Түүнчлэн хуулийг шинэчлэн найруулахдаа дараах зохицуулалтуудыг тусгах. Үүнд:

- Монгол Улсын нэгдэн орсон далайн салбарын олон улсын гэрээ конвенц, түүний нэмэлт, өөрчлөлтийн зайлшгүй мөрдөх шаардлагатай зарим зохицуулалтыг тусгах. Тухайлбал:
 - ✓ Далайн орчныг хамгаалах зорилгоор хөлөг онгоц далайг бохирдуулсан тохиолдолд хүлээлгэх хариуцлага, далбааны эзэн улсын хяналтын байцаагчийн үзлэг, шалгалт явуулах, хөлөг онгоцонд газрын тос, шингэн хорт болон хорт бодис, бохир ус, хөлөг онгоцноос гарсан хог хаягдал, агаарын бохирдлоос урьдчилан сэргийлэх үзлэг, шалгалт явуулах, гэрчилгээ олгох зохицуулалтыг тус тус тусгах /Хөлөг онгоцноос үүдэлтэй бохирдлоос сэргийлэх тухай конвенц, түүний нэмэлт, өөрчлөлт/
 - ✓ Хөлөг онгоцны техникийн үйл ажиллагааны стандартын хэрэгжилтийн үзлэг, шалгалтыг Монгол Улс бие дааж, эсхүл олон улсын мэргэжлийн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх, зөрчсөн тохиолдолд буруутай этгээдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх /Далайд хүний аюулгүй байдлыг хангах тухай конвенц, түүний нэмэлт, өөрчлөлт/
 - ✓ Хөлөг онгоцны багийн гишүүдэд тавигдах мэргэжлийн шаардлага болон тэдгээрийн гэрчилгээг баталгаажуулах, багийн гишүүд мэргэжлийн шаардлага хангаагүй, гэрчилгээг хуурамчаар үйлдсэн нь илэрсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тусгах /Дипломтой далайчдыг бэлтгэх болон ээлжийн ажиллагааны тухай конвенци, түүний нэмэлт, өөрчлөлт/
 - ✓ Хөлөг онгоцны даацын тэмдэглэгээг тодорхойлж, гэрчилгээ олгох зохицуулалтыг нэмж тусгах /Даацын тэмдэглэгээний тухай конвенц/
 - ✓ Хөлөг онгоц дээр ажиллаж, амьдарч байгаа далайчны хөдөлмөрийн нөхцөл, ажиллаж, амьдрах байр, хоол хүнсний хангамж, эрүүл мэндийн хамгаалал, эмнэлгийн тусламж, үйлчилгээ, халамж, хангамж болон нийгмийн хамгааллын талаарх үзлэг, шалгалт явуулах зохицуулалтууд

нэмэх /Дипломтой далайчдыг бэлтгэх болон ээлжийн ажиллагааны тухай конвенци, түүний нэмэлт, өөрчлөлт/

- Монгол Улсын нэгдэн орсон далайн салбарын олон улсын гэрээ, конвенцид “Аливаа улсын далбаан дор үйл ажиллагаагаа явуулах эрх бүхий хөлөг онгоцны хувьд захиргаа /Maritime Administration/ нь тухайн улсын Засгийн газар байна” гэх бөгөөд Засгийн газрын чиг үүргийг хэрэгжүүлэх эрх бүхий төрийн байгууллагын эрх зүйн байдлыг Монгол Улсын хууль тогтоомж болон дээрх олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэн тодорхой болгох;
- Хөлөг онгоцны бүртгэлийн болон техникийн хяналтын үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдэд уг асуудлыг эрхэлсэн төрийн байгууллагын зүгээс хяналт тавих, хяналтын мөрөөр ногдуулах хариуцлагын эрх хэмжээг тодорхойлох
- Далай ашиглах тухай хуулийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын механизмыг боловсронгуй болгох.
- Уг хуулийг дагаж гарах дүрэм, журмыг хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд нийцүүлэн боловсруулах.
- Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгатай холбогдуулан дараах хуулийн төслийг боловсруулах. Үүнд:
 - ✓ Хөдөлмөрийн тухай хуульд Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын төрийн далбаа мандуулсан хөлөг онгоцон дээрх талуудын хоорондын хөдөлмөрийн гэрээний болон түүнээс уламжилсан хөдөлмөрийн бусад харилцааг хамааруулахаар нэмэлт оруулах.
 - ✓ Зөрчлийн тухай хуульд хөлөг онгоц далайг бохирдуулсан, хөлөг онгоцны бүртгэл, техникийн хяналтын үйл ажиллагааны дүрэм, журам, стандартыг зөрчсөн, далайчны хөдөлмөрийн харилцаатай холбоотой болон Олон улсын гэрээ, конвенцийн шаардлагыг биелүүлээгүй, Далай ашиглах тухай болон бусад хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаарх зохицуулалтыг нэмэлтээр оруулах.
 - ✓ Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн эзэмшилд байгаа болон гадаадын иргэн, хуулийн этгээдийн эзэмшилд байгаа хөлөг онгоцыг бүртгэх тэмдэгтийн хураамжийг ялгавартайгаар тогтоохоор нэмэлт, өөрчлөлт оруулах.
 - ✓ Далай ашиглах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг тус тус боловсруулах.

--- о О о ---

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Нэг. Хууль тогтоомж, олон улсын гэрээ, бусад эрх зүйн акт

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он.
2. Хууль тогтоомжийн тухай хууль, 2015 он.
3. Далайд гарцгүй улсын далбаагаа мандуулах эрхийг хүлээн зөвшөөрөх тухай тунхаглал
4. “Далайд гарцгүй орны транзит худалдааны тухай” олон улсын конвенц
5. “Далайн эрх зүйн тухай” Нэгдсэн Үндэстний байгууллагын конвенц
6. “Олон Улсын Далайн Байгууллагын тухай” конвенц
7. “Олон Улсын Далайн Байгууллагын тухай” Конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулсан 1991 оны протокол
8. “Олон Улсын Далайн Байгууллагын тухай” Конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулсан 1993 оны протокол
9. “Далайд хүний аюулгүй байдлыг хангах тухай” олон улсын конвенц
“Далайд хүний аюулгүй байдлыг хангах тухай” конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулсан 1978 оны протокол
10. “Далайд хүний аюулгүй байдлыг хангах тухай” конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулсан 1988 оны протокол
11. “Далайд хөлөг онгоц мөргөлдөхөөс урьдчилан сэргийлэх олон улсын журмын тухай” конвенц
12. “Даацын тэмдэглэгээний тухай” олон улсын конвенц
13. “Даацын тэмдэглэгээний тухай” Конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулсан 1988 оны протокол
14. “Хөлөг онгоцны багтаамжийн хэмжилтийн тухай” олон улсын конвенц
15. “Дипломтой далайчдыг бэлтгэх болон ээлжийн ажиллагааны тухай” олон улсын конвенци, түүний нэмэлт, өөрчлөлт
16. “Хөлөг онгоцноос үүдэлтэй бохирдлоос сэргийлэх тухай” олон улсын конвенц
17. “Хөлөг онгоцноос үүдэлтэй бохирдлоос сэргийлэх тухай” олон улсын Конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулсан 1978 оны протокол
18. “Хөлөг онгоцноос үүдэлтэй бохирдлоос сэргийлэх тухай” олон улсын Конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулсан 1997 оны протокол (Хавсралт 6)

19. “Газрын тосны бохирдлоос учирсан хохирлын төлөө хүлээх иргэний хариуцлагын тухай” олон улсын конвенц
20. “Газрын тосны бохирдлоос учирсан хохирлын төлөө хүлээх иргэний хариуцлагын тухай” олон улсын конвенцид нэмэлт өөрчлөлт оруулсан 1992 оны протокол
21. “Хөлөг онгоцны шатахууны савны тосны бохирдлоос учирсан хохирлын төлөө хүлээх иргэний хариуцлагын тухай” олон улсын конвенц
22. “Хөлөг онгоцны гадаргууг хамгаалах системд хортой бодис ашиглахыг хянах тухай” олон улсын конвенц
23. “Хөлөг онгоцны тэнцвэржүүлэгч ус болон үлдэгдэл тунадасны хяналт ба менежментийн тухай” олон улсын конвенц
24. “Далайн нэхэмжлэлийн талаар хүлээх хариуцлагыг хязгаарлах тухай” конвенц
25. “Далайн нэхэмжлэлийн талаар хүлээх хариуцлагыг хязгаарлах тухай” конвенцийн 1996 оны протокол
26. Далайн хиймэл дагуулын олон улсын байгууллагын конвенц
27. “Аврах ажиллагааны тухай” 1989 оны олон улсын конвенц
28. “Далайн хөдөлмөрийн тухай” Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын Конвенц
29. “Далайн навигацын аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай” олон улсын конвенц
30. “Далайн навигацын аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай” олон улсын конвенцийн 1988 оны протокол
31. “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоол.
32. “Монгол Улсын нэгдэн орсон далайн салбарын олон улсын гэрээ, конвенцийг хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөө”, Засгийн газрын 2018 оны 201 дүгээр тогтоол.
33. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө.
34. “Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд хөлөг онгоц бүртгэх журам” Засгийн газрын 2003 оны 3 дугаар тогтоол.
35. “Хуулийн хэрэгжилтийг хангах, зөрчлийг арилгах асуудлаар чиглэл өгөх тухай” Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2009 оны 4 дүгээр тогтоол.
36. “Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын 2017 оны 11 дүгээр тогтоол.

Хоёр. Судалгаа, тайлан, төсөл, эмхэтгэл, ном, сэтгүүл

37. Олон Улсын далайн байгууллагын Аудитын дүгнэлт, зөвлөмж, 2016 он

38. “Монгол Улсын нэгдэн орсон далайн эрх зүйн салбарын олон улсын конвенц, протокол” Төрийн мэдээлэл 10 дугаар тусгай боть

39. “Монгол Улсын нэгдэн орсон далайн эрх зүйн салбарын олон улсын конвенц, протокол” Төрийн мэдээлэл 11 дүгээр тусгай боть

40. Korean Maritime Institute “Advisory Report on Maritime Transportation and Fishery for Mongolia” , 2011

Гурав. Гадаад хэл дээрх эх сурвалж

41. International Maritime Organization “Code for the Implementation of Mandatory IMO instruments”, 2007

42. International Maritime Organization “Resolution A.1070(28) IMO Instruments Implementation Code (III CODE)”, 2013

43. International Maritime Organization “Review of Maritime Transport” 2017

44. World Maritime University “Ship registration: A critical analysis” 2010

45. International Maritime Organization “Resolution MSC.349(92) Code for Recognized Organizations (RO CODE)”, 2013

---o O o---